

Хэнтий аймгийн Дадал сумын Монгол Ардын Намаас 2020 оны сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох мөрийн хөтөлбөр

Уриа: ХҮЧ НЭМЬЕ

Нэр: НОГООН ХӨГЖИЛ 2020-2024

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1. Орлоготой иргэн

- 1.1.1. Гарааны бизнес эрхлэгч наарт бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 1.1.2. Орлого багатай өрхийн ажил эрхлээгүй насанд хүрсэн гишүүдийг бүртгэлжүүлж, мэргэшил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- 1.1.3. Суманд хийгдсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг бодлогоор дэмжиж, тэгш гараанаас бизнес эрхлэх нөхцлийг бий болгоно.
- 1.1.4. Түр болон байнгын ажлын байраар нутгийн иргэдийг хангах бодлогыг баримтлан ажиллана.
- 1.1.5. Хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд эрсдэлгүй технологи бүхий хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдэл, бага орлоготой өрхийн тоог бууруулна.
- 1.1.6. Төмс хүнсний ногоо тариалагчдыг дэмжиж шинээр зоорь, хүлэмж барих иргэд, бүлэг, нөхөрлөл, хоршоо, ААН-үүдийг зээлийн бодлогоор дэмжин ажиллана.
- 1.1.7. Жимс жимсгэнэ тариалагчид болон туслах аж ахуй буюу гахай тахиа, зөгий үржүүлэх иргэд, бүлэг, нөхөрлөл, ААН-үүдийг хүү зээлийн бодлогоор дэмжин ажиллана.
- 1.1.8. Сумын иргэдийг аялал жуулчлал эрхлэх гарааны бизнес, төсөл хөтөлбөр, зээлд хамруулах ажлыг зохион байгуулна.
- 1.1.9. Анх удаа орон сууцны зээл авч байгаа нийгмийн даатгалын шимтгэл төлдөг иргэдэд урьдчилгаагүй, бага хүүтэй зээлийн хөтөлбөрт хамрагдах, анх удаа байр авч байгаа бага, дунд орлоготой иргэдэд 4-6 хувийн хүүтэй орон сууцны ипотекийн зээл олгох Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлж ажиллана.

1.2. Эрүүл иргэн



- 1.2.1. Иргэн бүрийг эрүүл мэндийн оношилгоонд жил бүр хамруулах ажлыг зохион байгуулна.
- 1.2.2. "Элэг бүтэн Монгол" хөтөлбөрийг үргэлжлүүлж, "Хавдрын эсрэг хамтдаа" хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ.
- 1.2.3. "Эрүүл шүд-Эрүүл хүүхэд" хөтөлбөрийн хүрээнд шүдний мэргэжлийн эмчтэй болох арга хэмжээ авч, шүдний кабинетийг байнгын ажиллагаатай болгоно.
- 1.2.4. Хүүхдийн хоолойн архаг (ангина) өвчнийг эрт илрүүлэн эмчлэх, ирээдүйд учрах эрүүл мэндийн эрсдэлээс бага насанд нь сэргийлэх "Эрүүл ирээдүй" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.2.5. Сумын ЭМТ-ийн албан хаагчдын ажиллах орчинг сайжруулан, сувилагч, асрагчаар бүрэн хангана.
- 1.2.6. Сумын ЭМТ-ийг халуун, хүйтэн ус, ариун цэврийн иж бүрэн байгууламжтай болгоно.
- 1.2.7. "Идэвхтэй эрүүл амьдрал" хөтөлбөрийг хэрэгжүүлж, дасгал хөдөлгөөн, зөв хооллолт, стресс бухимдлаас ангид байх эрүүл амьдралын дадал хэвшлийг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлнэ.
- 1.2.8. Эрүүл зөв амьдралын тухай мэдлэг мэдээллийг иргэдэд олгох сургалт, зөвлөгөөг бүх хэлбэрээр зохион байгуулна.
- 1.2.9. Байгалиа түшиглэсэн уламжлалт анагаах ухааныг дэлгэрүүлж, аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга ажиллагаанд иргэдээ сургах ажлыг зохион байгуулна.
- 1.2.10. Өвчтөний хоол хүнсэнд экологийн цэвэр бүтээгдэхүүн хэрэглэх зорилгоор туслах аж ахуй хөгжүүлнэ.
- 1.2.11. Эмнэлгийн хог хаягдлыг хүний эрүүл мэндэд хоргүй, байгаль орчинд ээлтэй болгон боловсруулах шинэ технологи, тоног төхөөрөмжөөр хангана.
- 1.2.12. Эрүүл мэндийн төвийн бохир усны шугамыг шинэчлэн засварлана.
- 1.2.13. Эрүүл мэндийн төвийн байрны өргөтгөл, урсгал засвар хийлгэж аюулгүй ажиллагааг хангуулна.
- 1.2.14. Эрүүл мэндийн төвийг орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангах нөхцлийг бүрдүүлнэ.
- 1.2.15. Багийн эмч нарыг баг дээрээ ажиллах нөхцөл бололцоогоор хангаж, унаажуулах ажлыг зохион байгуулна.
- 1.2.16. Эм, эмнэлгийн хэрэгсэлийн чанар, аюулгүй байдал болон худалдах үйл ажиллагаанд хяналт тавьж, иргэдийг найдвартай эм, тариагаар хангаж, хөнгөлөлттэй эмийн үйлчилгээг бүрэн хэрэгжүүлнэ.

231714429
ЗА0046 907



1.3. Боловсролын хөгжил

- 1.3.1. Цэцэрлэг, сургуулийн байрны өргөтгөл хийж, урсгал болон их засвар хийнэ.
- 1.3.2. Эко цэцэрлэг, эко сургууль дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ
- 1.3.3. Үндэсний болон Буриадын өв соёл, зан заншлыг дээдэлсэн сургалтын тусгай хөтөлбөрийг ЕБС, СӨБ-ын суралцагсадад эзэмшүүлэн түгээнэ.
- 1.3.4. Ерөнхий Боловсролын Сургууль, цэцэрлэгийн багш, ажилтны нийгмийн болон хөдөлмөрийн үнэлэмжийг үнэлэх бодлого хэрэгжүүлнэ.
- 1.3.5. Багш нарын мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжиж, мэргэжил дээшлүүлэх гадаад, дотоодын сургалт, үйл ажиллагаанд хамруулж, “Чадварлаг багш” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, багш нарыг урамшуулах асуудлыг шийдвэрлэнэ.
- 1.3.6. Цэцэрлэгийн бүлэг бүрд 2 ээлжийн бүлгийн багш ажиллуулах боломжийг бүрдүүлнэ.
- 1.3.7. Хүүхэд харах үйлчилгээний чанар, хүртээжмийг нэмэгдүүлж, яслийн үйлчилгээг шинээр бий болгоно.
- 1.3.8. “Үдийн хоол” хөтөлбөрийг үргэлжлүүлж, хүүхдэд шим тэжээл, амин дэмээр баялаг хоолоор үйлчилнэ.
- 1.3.9. Сэтгэл зүйч-мэргэжилтнийг ЕБС-д ажиллуулна.
- 1.3.10. Тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй хүүхэд сургууль, цэцэрлэгт сурах, хөгжих орчин бүрдүүлнэ.
- 1.3.11. Хичээлээс гадуурх сургалтын хөтөлбөр боловсруулж, сонирхол, авьяас чадварыг нээн хөгжүүлэх, сонгон секц, дугуйлангийн үйл ажиллагааг хөгжүүлнэ.
- 1.3.12. Сургуулийн дотуур байр, ногоон хөгжлийн байгууламж, спорт заал, цайны газар, мэдээлэл зүйн сургалтын танхимыг тохижуулж, тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй суралцагчдад зориулсан тохируулгат орчин бүрдүүлнэ.
- 1.3.13. Сургууль, цэцэрлэгийн нүхэн жорлонг өөрчилж, орчин үеийн ариун цэврийн өрөө, эко жорлонтой болгож, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.
- 1.3.14. Сум орон нутагтаа ажиллаж амьдарч байгаа иргэдийн хүүхдийг сургалтын төлбөрийн тэтгэлэг олгох “Үндэсний тэтгэлэгт хөтөлбөр”-ийг орон нутагтаа хэрэгжүүлнэ.
- 1.3.15. Сум орон нутагтаа ажиллаж амьдрах сонирхолтой иргэн, суманд нэн шаардлагатай ажил, мэргэжлээр сурч байгаа

7
4082

оюутнуудыг хамруулах “Төрөлх нутагтаа бид” боловсон хүчин, хүний нөөцийн хөтөлбөр хэрэгжүүлнэ.

- 1.3.16. Сумын номын санг олон нийтэд хүртээмжэйгээр тохижуулан түүгээр үйлчлэх санал санаачлагыг дэмжих, ном уншсан хүүхэд иргэдийг урамшуулах, ном унших хөдөлгөөнийг өргөжүүлнэ.
- 1.3.17. Бүхий л түвшинд зохион байгуулагдаж буй олимпиад, уралдаан, тэмцээнд оролцож, амжилт үзүүлсэн суралцагч, багш, багийг дэмжиж урамшуулна.
- 1.3.18. “Тогтвортой хөгжлийн боловсрол- 2” төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангулна.

1.4 Хүүхэд хамгаалал, гэр бүл, залуучуудын хөгжил

- 1.4.1. Өрхийн амьжиргааны түвшинг тогтоох аргачлалд тулгуурлан хүнсний талон болон бусад нийгмийн халамжийн үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлнэ.
- 1.4.2. Орлого багатай өрхийн нийгмийн хамгаалал, амьжиргааг дээшлүүлэх олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг хэрэгжүүлнэ.
- 1.4.3. Угийн бичгээ хөтлөх, цус ойртолтоос урьдчилан сэргийлэх, удмын сангаа хамгаалах ажлыг зохион байгуулна.
- 1.4.4. Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, нийгмийн төлөвшилтийг дэмжихэд эцэг, эхчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 1.4.5. Хүүхдийн тоглоомын талбай байгуулах санаачлагыг дэмжиж, орчны стандартыг мөрдүүлж, хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлж, хяналтыг сайжруулна.
- 1.4.6. Гэр бүл, хүүхэд, оюутан, залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх орчин бий болгоход зориулсан төвийг шинээр байгуулна.
- 1.4.7. Залуучуудын хөгжлийг дэмжих сан байгуулж, дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

1.5. Тусгай хэрэгцээ /Хөгжлийн бэрхшээл/-тэй иргэд, ахмадыг дэмжих чиглэлээр

- 1.5.1. Тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй иргэдийн эрх, оролцоог хангаж, нөхөн сэргээх эмчилгээ, сувилгаа болон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэн тэдний дунд төрөл бүрийн урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулна.

- 82
- 1.5.2. Байнгын асаргаа шаардлагатай тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй иргэд, ахмадуудыг төрөлжсөн асрамж, сувиллын үйлчилгээнд байнга хамруулна.
 - 1.5.3. Ахмадын хорооны байрны урсгал засварыг жил бүр хийж, ахмадыг чөлөөт цагаа өнгөрүүлэх боломжоор хангана.
 - 1.5.4. Ахмадын урлаг, спортын арга хэмжээг жил бүр зохион байгуулна.

1.6. Бахархал, өв соёл, спорт

- 1.6.1. Орон нутгийг судлах музей, Тэмүүжиний бага нас музей болон хувийн гэр музейн байрны урсгал засвар, үзмэр баяжилтыг байнга нэмэгдүүлнэ.
- 1.6.2. Дадал sumaас төрөн гарсан алдартнуудын амьдрал, гавьяа зүтгэл, бүтээлийг сурталчилсан Дадал сумын түүхийн ном товхимолыг шинээр гаргана.
- 1.6.3. Дадал sumaас төрөн гарсан алдартнуудыг бахархан дурсах зорилгоор сумын зарим байгууллагуудыг тэдгээрийн нэрэмжит болгох ажлыг зохион байгуулна.
- 1.6.4. Дадалын 9 бахархалт газрыг алдаршуулж, сурталчилан аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон тохижуулж эргэлтэнд оруулна.
- 1.6.5. Соёлын төвийн орон тоог нэмэгдүүлж, шаардлагатай боловсон хүчинээр хангана.
- 1.6.6. Ганданчоймпиллин хийдийн менежментийг сайжруулан, төр, сүсэгтэн олон, хийдийн уялдаа холбоог нэмэгдүүлнэ.
- 1.6.7. Суманд орон тооны биеийн тамирын арга зүйч ажиллуулан, иргэдийг идэвхитэй спортоор хичээллүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.
- 1.6.8. Сумын спорт цогцолборын шаардлагатай орон тоо, тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг холбогдох газарт уламжлан шийдвэрлүүлнэ.
- 1.6.9. Багуудын урлаг спортын наадмыг жил бүр зохион байгуулж, уламжлал болгоно.
- 1.6.10. “Балжийн андууд” мөсөн шагайн олон төрөлт тэмцээнийг Олон улсын хэмжээнд зохион байгуулж хэвшинэ.
- 1.6.11. Сум орон нутагт үндэсний хэмжээний спортын тэмцээн уралдааныг хүлээн авч зохион байгуулна.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

2.1. Дэд бүтэц, барилга байгууламж

Дэд
1

23171
ЮА0046



- 2.1.2. Сумын төвд суурин газрын 3.5 км хатуу хучилттай бетонон авто зам тавина.
- 2.1.3. Халzan толгойд Цанын баазыг байгуулах ажлыг холбогдох байгууллагад уламжлан улсын төсөвт тусгуулах ажлыг зохион байгуулна.
- 2.1.4. Сумын төвд Хүүхэд залуучуудын соёл амралтын хүрээлэн байгуулах ажлыг холбогдох байгууллагад уламжлан улсын төсөвт тусгуулах ажлыг зохион байгуулна.
- 2.1.5. Сумын төвийн цэвэрлэх байгууламжийг шинээр барьж байгуулах асуудлыг холбогдох газарт уламжлан шийдвэрлүүлнэ.
- 2.1.6. Сумын төвийн айл өрхүүдийн хашаа, гудамжны эгнээ, төлөвлөлтгүй олгогдсон газруудыг цэгцлэх “Хашаа” төсөл хэрэгжүүлнэ.
- 2.1.7. Төсөвт байгууллагуудыг инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбож бүрэн дуусгана.
- 2.1.8. Сумын төв зам, гудамж, талбайг бүрэн камержуулна.
- 2.1.9. “Мянганы суут хүн-Их эзэн Чингис хаан” Түүхэн аялал жуулчлалын үндэсний парк төслийн хүрээнд “Чингис хаан” цогцолбор, аялал жуулчлалын батлагдсан маршрутын дагуу “Мэдээлэл, үйлчилгээний жишиг төв”-ийг барьж дуусган эдийн засгийн эргэлтэд оруулна.
- 2.1.10. “Чингис хаан” цогцолборын дагалдах ажлын хүрээнд 2.6 км хатуу хучилттай авто зам, 250 авто машины зогсоол, цахилгаан дамжуулах шурам, нийтийн ариун цэврийн байгууламж зэрэг дагалдах дэд бүтцүүдийг барьж дуусгана.
- 2.1.11. Сөөгтэй дэх “Дэлүүн болдог” нисэх буудлын аэродром, барилга байгууламжийг барьж дуусгана.
- 2.1.12. Сумын төвийн холбогдох суурьшлын бүсэд цахилгаан дамжуулах шугам татаж, цахилгааны уналттай газарт дэд станц нэмж байрлуулна.

2.2. Хүнс, Хөдөө аж ахуй

- 2.2.1. Бэлчээр менежментийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, худаг усны хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэн бэлчээрийн талхлалтыг бууруулна.
- 2.2.2. “Дадал үхэр” сайжруулсан омгийг баталгаажуулж, үзлэг ангилалт тогтмол хийнэ.
- 2.2.3. Мал, малын гаралтай түүхий эд, цагаан идээ, сүү сүүн бүтээгдэхүүн, төмс хүнсний ногооны үзэсгэлэн худалдааг жил

14297
9074082

бүр зохион байгуулж, аймаг, улсын үзэсгэлэн худалдаанд малчид болон өрхийн үйлдвэрлэгчдийг оролцоход дэмжлэг үзүүлнэ.

- 2.2.4. Мал эмнэлгүүдийг дэмжиж, малын эмч, зоо-техникчдийг тэтгэлэгт хөтөлбөрөөр бэлтгэн, ХАА-н тасгийн орон тооны дутагдлыг бүрэн хангаж ажиллуулна.
- 2.2.5. Max, махан бүтээгдэхүүн болон малын гаралтай түүхий эдийн үнийг нэмэгдүүлэх, малчдын орлогыг нэмэгдүүлэх бүхий л боломжийг судлан хэрэгжүүлнэ.
- 2.2.6. Хөдөө аж ахуйн салбарт малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх “Илгээлтийн эзэн – III” аяныг сумандаа хэрэгжүүлнэ.
- 2.2.7. “Монгол мал-2” хөтөлбөрийг хэрэгжилтийг хангуулж, малыг эрүүлжүүлэх, чанар, ашиг шимиийг сайжруулах ажлыг эрчимжүүлж, малын тоог чанарт шилжүүлж ашиг шим, хүртээмжийг сайжруулах, малын генийн санг хамгаалах ажлыг зохион байгуулна.
- 2.2.8. Малыг ялган тэмдэглэх, малыг им тамга, тэмдэг, зүсмийн бүртгэлд бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлж, бүртгэл, мэдээллийн сантай болгоно.
- 2.2.9. Малын халдварт өвчинтэй тэмцэх, мал сүргийг бүрэн вакцинуулах, гоц халдварт өвчингүй, тайван бүсийг баталгаажуулна.
- 2.2.10. Малыг эрүүлжүүлэх ванн, тарилгын хашааг баг бүрт барьж, мал эмнэлэгийн үйлчилгээг бүрэн хангана.
- 2.2.11. Сумын иргэд, малчдын өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн газар, хадлангийн талбай ашиглалтыг баталгаажуулан маргаан зөрчилгүй болгоно.
- 2.2.12. Max, сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулах өрхийн болон жижиг дунд үйлдвэрүүдийг хөгжүүлж, “Чингис хааны төрсөн нутагт үйлдвэрлэв” шошгот 3-аас доошгүй нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.
- 2.2.13. Байгалийн дагалт баялагийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, “Чингис хааны төрсөн нутгийн өгөөж” шошгот 3-аас доошгүй брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.
- 2.2.14. Төмс, байцаа, манжин, лууван, сонгино, сармис зэрэг хүнсний ногоогоор сумын хэрэгцээг бүрэн хангана.
- 2.2.15. Хүлэмж, агуулахын аж ахуйг хөгжүүлэх замаар хүнсний ногооны сумын хэрэгцээг жилийн турш тогтвортой хангана.



- 2.2.16. "Атар-4" аяныг орон нутагтаа хэрэгжүүлж, тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- 2.2.17. Царгас зэрэг тэжээлийн ургамал тариалах санал санаачлагыг дэмжинэ.
- 2.2.18. Эргэлтэнд байгаа газар тариалангийн газрыг бүрэн хашаажуулж, малчид ААН-үүдийн хоорондох маргааныг турвалсан гэрээгээр зохицуулна.

2.3. Төрөлжсөн аялал жуулчлал

- 2.3.1. Зуны болон өвлүүн аялал жуулчлалын эвент арга хэмжээ шинээр бий болгож, дэлгэрүүлэн хөгжүүлнэ.
- 2.3.2. Байгалийн болон түүхэн аялал жуулчлалын чиглэл маршрутын дагуу тэмдэг тэмдэглэгээ, бүтээгдэхүүний тохижуулалт хийж, учирч болзошгүй байгаль орчныг бохирдлоос урьдчилан сэргийлнэ.
- 2.3.3. Аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор дотоод гадаадын жуулчдыг хүлээн авах стандартын шаардлагад нийцсэн зочид буудал, жуулчдын бааз барих санаачлагыг дэмжинэ.
- 2.3.4. Аялал жуулчлалын үйлчилгээний чанар, эрүүл ахуйн шаардлагыг сайжруулж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 2.3.5. Аялал жуулчлалын ажилтан, хөтөч, тайлбарлагч, орчуулагч бэлтгэх сургалтуудыг үе шаттай зохион байгуулж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 2.3.6. Нутаг орноо сурталчлан таниулах ажлыг дэмжиж, иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн гар урлал, сувенир, бусад бичил худалдаа, үйлчилгээ үзүүлэх боломжоор хангана.
- 2.3.7. Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэн, нутгийн иргэд, бүлэг, нөхөрлөлийг орлого олох боломжийг бүрдүүлэн дэмжиж ажиллана.
- 2.3.8. Тусгай сонирхолын буюу морин аялал, зураг авах аялал, уулын бартаат замын аялал, усан аялал, ан амьтан загас ажиглах аялал зэрэг арга хэмжээнүүдийг хөтөлбөрийн дагуу зохион байгуулалтанд оруулна.
- 2.3.9. Аялал жуулчлалаас малчид, нутгийн иргэдийг ашиг хүртэх бүхий л бололцоог хангуулан зохион байгуулалтад оруулж ажиллана.
- 2.3.10. Аялагч, жуулчдын түр отоглох, хоноглох газруудыг стандартад нийцүүлэн шинээр 3 -ыг байгуулж тохижуулах замаар замбараагүй аялал жуулчлалыг хязгаарлана.

317144297
A0046 9074

ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

3.1. Шударга ёс, цахим засаглал

- 3.1.1. "Дадал ногоон хөгжлийн төлөөх загвар сүм-2024" хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг хангулан ажиллана.
- 3.1.2. Сонгуулийн үр дүнд томилогдсон, сонгогдсон албан тушаалтнуудтай хариуцлагын гэрээ, батламж байгуулж, алдаа гаргасан, нийтийн язгуур эрх ашгийг хохироосон бол хуулийн болон ёс зүйн хариуцлагыг тооцож ажиллана.
- 3.1.3. Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх таслан зогсоох ажлыг эрчимжүүлнэ.
- 3.1.4. Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөр, тухайн жилийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, сумын төсвийг сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй нийцүүлэн бэлтгэх болно.
- 3.1.5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хэсгийн төлөөлөгч, цагдаагийн тусгай хэрэгсэлээр хангаж, унаажуулах ажлыг зохион байгуулна.
- 3.1.6. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн үйл ажиллагаа, ёс зүйд хяналт тавьж, хууль зөрчсөн ёс зүйн алдаа гаргасан тохиолдолд хариуцлага хүлээлгэж, намууд эргүүлэн татдаг соёл хандлагыг төлөвшүүлнэ.
- 3.1.7. Засаг дарга ашиг сонирхолын болон хууль тогтоомж зөрчсөн аливаа үйлдэл гаргавал тухай бүрд нь хэлэлцэн хариуцлага тооцон ажиллана.
- 3.1.8. Төсөвт байгууллагын дарга, эрхлэгч нарыг үлс төрөөс ангид байлгаж, явцуу ашиг сонирхолд бус, нийтийн эрх ашгийн төлөө үйлчилдэг бодлогын орчин бүрдүүлнэ.
- 3.1.9. Сум хөгжүүлэх сан, жижиг дунд бизнесийг дэмжих сангудын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй хяналттай тогтоолцоонд бүрэн шилжүүлнэ.
- 3.1.10. Төрийн албан хаагчдын интернет орчин /фэйсбуук, сошиал/-д ажиллах цагийг хязгаарлаж, ажлын цагт сошиал сүлжээнд орохгүй болгоно.
- 3.1.11. Төрийн байгууллагад байгаа мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг бүрэн халж, иргэд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай авдаг "Нэг иргэн- Нэг бүртгэл" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангулна.

3.1.12. Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл, хүсэлтийг шуурхай шийдэж, тушаал, шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг цахим хэлбэрээр хянадаг болно.

3.2. Мэргэшсэн, ёс зүйтэй төрийн алба

3.2.1. Хүнд сурталгүй төрийн үйлчилгээ нэвтрүүлэх зорилгоор төрийн байгууллагуудын үйлчилгээг сайжруулж, төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэн чадавхжуулж, ёс зүй сахилга хариуцлагыг дээшлүүлнэ.

3.2.2. Согтууруулах ундааны хэрэглээг төрийн аль ч шатны байгууллагад таслан зогсоож, архигүй орчин бүрдүүлэх, ажлын цаг, албан томилолттой үед архи уусан албан хаагчид хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авна.

3.2.3. Төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ танил талдаа давуу тал олгохгүй байх, явцуу сонирхол, намын харьяаллаар иргэдэд ялгавартай хандахгүй байх зарчмыг бүрэн хэвшүүлнэ.

3.3. Хил хамгаалалт, гадаад хамтын ажиллагаа

3.3.1. Хилчдийн сургуулийн өмнөх насын хүүхдүүдэд шинээр цэцэрлэгийн байр барьж, ая тухтай суралцах нөхцлийг бүрдүүлнэ.

3.3.2. Хилчдийг эрүүл аюулгүй хүнсээр хангах зорилгоор төмс, хүнсний ногоо тариалах газрын асуудлыг шийдвэрлэж, дотоод хэрэгцээг нь хангуулах ажлыг зохион байгуулж дэмжинэ.

3.3.3. Хилчин албан хаагчдын “Хилчин хотхон” байгуулах газрын асуудлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

3.3.4. Хил хамгаалалтад туслах хүчний үйл ажиллагааг сайжруулж, хил хамгаалалтанд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

3.3.5. Хөрш сумд болон нийслэлийн Сонгинохайрхан дүүрэгтэй хамтын ажиллагааг сайжруулж, харилцан туршлага нэвтрүүлнэ.

3.3.6. ОХУ-ын Ага, Дульдурга, Кыра район болон БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шинэ барга зүүн хошуу, Манжуур хоттой хамтын ажиллагааг үргэлжлүүлэн шинэ шатанд гаргана.

ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

4.1. Хүрээлэн буй орчин

4.1.1. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар болон тусгай хэрэгцээнд авсан газруудын хамгаалалтын горимыг шинэчлэн мөрдүүлж ажиллана.



- 4.1.2. Онон-Балжийн БЦГ-аас зарим газрыг чөлөөлүүлж, зарим газрыг нэмж оруулах талаар холбогдох дээд байгууллагад уламжлана.
- 4.1.3. Суурин газрын ногоон байгууламжийн эзлэх талбайн хэмжээг 50 хувиар нэмэгдүүлнэ.
- 4.1.4. Ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийг эрчимжүүлж нийт 300 га-д ойжуулалт хийж, ойжуулалтын жишиг талбайг 20 га-д хүргэнэ.
- 4.1.5. Ойн нөөцийг хамгаалах, үр өгөөжтэй ашиглах, нөхөн сэргээх менежментийг сайжруулж, ой зохион байгуулалт хийлгэнэ.
- 4.1.6. Ойн хөнөөлт, өйлөөлж, ой хээрийн түймэртэй өйлөүх ажлыг зохион байгуулж, түүнээс үүссэн хохирлыг бууруулах, байгалийн гамшгийн эрсдлээс урьдчилан сэргийлэх ажлыг үзүүлж, ажиллана.
- 4.1.7. Агнуурын бүс нутгуудын менежментийг сайжруулж, менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангулан ажиллана.
- 4.1.8. 10 - аас доошгүй булагийн эхийг хашиж, хамгаалан тохижуулж, хүн мал амьтны ундны эх үүсвэрийг хамгаална.
- 4.1.9. Нэгдсэн хогийн цэгийг судалгааны үндсэн дээр шинээр байгуулж, хуучин хогийн цэгийг ландфилын аргаар цэвэрлэж, нөхөн сэргээлтийн ажлыг хийнэ.
- 4.1.10. Хог хаягдлын нэгдсэн менежмент төлөвлөгөөг боловсруулж, хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах, байгальд ээлтэй байдлаар зайлцуулах ажлыг шат дараатай зохион байгуулна.
- 4.1.11. Хог хаягдлыг бууруулах, ангилан ялгах талаар иргэдийн мэдлэг ухамсыг дээшлүүлэх дадал суулгах сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлнэ.

4.2. Хариуцлагатай уул уурхай

- 4.2.1. Дадал сумыг уул уурхайгүй сум болгон зарлаж, хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлгүй сум болгоно.

ТАВ. БАГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 5.1.1. Багийн нийтийн хурлыг улирал бүр, багийн өдөрлөгийг сар тутам зохион байгуулж хэвшинэ.
- 5.1.2. "Багийн хөгжил" хөтөлбөр хэрэгжүүлж, жишиг багтай болж, хөрөнгө оруулалтыг үе шаттай нэмэгдүүлнэ.
- 5.1.3. Иргэдийн бүрэн оролцоог ханган орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх ажлыг эрэмбэлж, санхүүжилтын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

231714429
ЮА0046 907

- 5.1.4. Багуудад соёлын арга хэмжээ зохион байгуулах техник тоног төхөөрөмжөөр хангана.
- 5.1.5. Багуудын төв, Галттай хэсгийн байрыг засвар, тохижилтыг жил бүр хийнэ.
- 5.1.6. Багийн Засаг дарга нарыг баг дээр нь ажиллуулах нөхцөл бололцоог ханган, унаажуулна.
- 5.1.7. Уужимын голд модон гүүр тавина.
- 5.1.8. Хөрхон голд бирваз байрлуулж, иргэдийг ая тухтай зорчих орчныг бүрдүүлнэ.
- 5.1.9. Шувуутын шинэ давааг засаж, тохижуулна.
- 5.1.10. Сумын төвийн худгуудыг ухаалаг худаг болгон СМАРТ картын сисемд шилжүүлж, 24 цагийн ажиллагаатай болгоно.
- 5.1.11. Сумын төвд нийтийн жишиг, байгаль орчинд ээлтэй эко жорлон 3-аас доошгүй газарт байрлуулна.
- 5.1.12. Сумын төвийн дэлгүүрүүдийн дунд нэгдсэн авто зогсоол байгуулна.
- 5.1.13. Сум төв гудамжинд зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх замын тэмдэг тэмдэглэгээг стандартын дагуу хийж аюулгүй ажиллагааг хангана.
- 5.1.14. Аялал жуулчлалын бүс нутаг болж байгаатай холбогдуулан суурьшлын бүсэд мал олноор оруулахгүй байх бодлого баримтлана.
- 5.1.15. Баян-Овоо багт орлогод нийцсэн, түрээсийн 8 айлын инженерийн хангамжтай орон сууцаар барина.

-оо-

